



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 20 өдөр

Дугаар А/14

Чингис хот

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулж
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын (а), Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02 дугаар тогтоол “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Цагаан сар–2020” үзэсгэлэн худалдааг 2020 оны 02 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд Чингис хотод зохион байгуулсугай.

2. Үзэсгэлэн худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, үзэсгэлэн худалдаанд шаардагдах хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үзэсгэлэн худалдаанд шаардагдах 1960500 /нэг сая есөн зуун жаран мянга таван зуун/ төгрөгийн хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, “Цагаан сар–2020” үзэсгэлэн худалдааны бэлтгэлийг хангаж, зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /Г.Хэрлэнчулуун/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

231010087

Аймгийн Засаг даргын 2020 оны
...01... дугаар сарын 20...өдрийн 1/14...
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт!

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч	Г.Хэрлэнчулуун	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга	Ж.Энх-Амгалан	Аймгийн Хүнс Хөдөө аж ахуйн газрын дарга
Гишүүд	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	Г.Лхагвахатан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	С.Оюун-Эрдэнэ	ЗДТГ-ын дотоод ажил, хэвлэл мэдээлэл хариуцсан Мэргэжилтэн
	Д.Амаржаргал	Цагдаагийн газрын Нийтийн хэв журмын тасгийн дарга
	Ц.Идэрбат	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
	Б. Сүнгээ	Мэргэжлийн хяналтын газрын дарга
	О.Гомбобаатар	Өндөрхаан хот тохижилт орон нутгийн төрийн өмчит үйлдвэрийн газрын дарга
	Д.Батболд	Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын Хэнтий аймаг дахь салбарын дарга
	Г.Энхзаяа	Ажил олгогч эздийн холбооны дарга
	Б.Эрийнтовч	Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны тэргүүн
	Т.Доной	Зүүн бүсийн төв "Эвт худалдааны төв"-ийн захирал

Аймгийн Засаг даргын 2020 оны
..... дугаар сарын..... өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

“ЦАГААН САР–2020” ҮЗЭСГЭЛЭН ХУДАЛДААНЫ ТӨСӨВ

д/ д	Арга хэмжээ	Тоо	Өргөмжлөл /нэг бүрийн үнэ/	Мөнгөн шагнал /дүн/	Зардлыг хариуцах байгууллага
Шагнал, урамшуулал					
Шилдэг оролцогч					
1	Шилдэг сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	1	40.0	50.0	АЗДТГ
2	Шилдэг гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	1	40.0	50.0	
3	Шилдэг махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	1	40.0	50.0	
4	Шилдэг нөөшилсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	1	40.0	50.0	
5	Шилдэг модон эдлэл, гэр ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	1	40.0	50.0	
6	Шилдэг бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	1	40.0	50.0	
7	Шилдэг Үндэсний хувцас үйлдвэрлэгч	1	40.0	50.0	
8	Шилдэг арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч	1	40.0	50.0	
Дүн			320.0	400.0	
Нийт дүн				720.0	
Зохион байгуулалт сайтай оролцсон сум					
9	Сум 1-р байр	1	40.0	150.0	АЗДТГ
10	Сум 2-р байр	1	40.0	130.0	
11	Сум 3-р байр	1	40.0	100.0	
Дүн			120.0	380.0	
Нийт дүн				500.0	
Бусад					
12	Анонс дотор /7*5/	1	9.5	332.5	АЗДТГ
13	Анонс гадна /4*6/	1	9.5	228.0	
14	Энгэрийн тэмдэг	30	4.0	120.0	
15	Урилга хөтөлбөр	20	3.0	60.0	
Дүн				740.5	
Нийт дүн				1960.5	